



КОНРАД-АДЕНАУЭР-САН



ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ

# НОГООН ХӨГЖИЛ



---

Монгол улс,  
Улаанбаатар-15141  
Эрх чөлөөний талбай, Ш/Х-90  
Оранж Плаза, 606 тоот

Утас 1: +976-11-319006  
Утас 2: +976-11-320393  
И-Мэйл: [info@civilwillgreen.mn](mailto:info@civilwillgreen.mn)  
Вэб Хуудас: [www.civilwillgreen.mn](http://www.civilwillgreen.mn)

---



## ИРГЭН ТАНАА

Өнөөгийн технологийн асар хурдацтай хөгжлийн үе шаттай хөл нийлүүлэн ажиллаж, амьдарч буй, Монгол улсынхаа нийт ард иргэддээ “Ногоон хөгжил” -ийн талаархи ойлголтыг нэмэгдүүлэх, эцэг өвгөдөөс өвлөгдөж ирсэн үзэсгэлэнт сайхан байгаль орчноо хайрлан хамгаалах, зүй зохистой ашиглаж, амьдрахад энэхүү хэвлэмэл тараах материал зориулагдсан болно.

Тус тараах материалыг хэвлүүлэхэд санхүүгийн бүрэн дэмжлэг үзүүлсэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Конрад-Аденауэр-Сангийн хамт олонд гүн талархалаа илэрхийлье.

ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.ДАРАМДОРЖ

**МОНГОЛЧУУДАА,  
БАЙГАЛЬ ДЭЛХИЙГЭЭ  
ХАЙРЛАН ХАМГААЛЖ, САЙХАН  
АМЬДАРЦГААЯ**



## МОНГОЛ УЛСЫГ НОГООН ХӨГЖИЛ РҮҮ ХӨТЛӨХ ШИНЭ БОДЛОГО БАТЛУУЛЛАА

2030 он хүртэл Монгол Улсын тогтвортой хөгжлийн суурь баримт бичиг болох Ногоон хөгжлийн бодлогыг УИХ-аар батлууллаа. Ногоон хөгжлийн бодлого нь эдийн засгийн өсөлтийг бий болгохдоо байгаль орчны доройтол, бохирдлоос сэргийлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан, хүн амын амьдралын чанарыг сайжруулж, нийгмийн тэгш байдлыг хангахад оршиж байна. Түүнчлэн дэлхий нийтээр ногоон эдийн засгийн хөгжил рүү тэмүүлж буй энэ цаг үед НҮБ-ын дэмжлэг авах анхны 7 орны нэг Монгол улс болов.





## МОНГОЛ УЛС, ДЭЛХИЙН УЛСЫН ОРНУУДЫН ӨМНӨ ХАРИУЦЛАГАТАЙ ҮҮРЭГ ХҮЛЭЭЛЭЭ

НҮБ-ын Байгаль орчны Ассамблейн Ерөнхийлөгчөөр Байгаль Орчин Ногоон Хөгжлийн сайд С.Оюун сонгогдлоо. Ингэснээр байгаль орчны асуудлыг дэлхий нийтийн анхааралд хүргэж, хүн төрөлхтний өмнө тулгамдсан сорилт бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд томхон түлхэц үзүүлдэг, байгаль орчны асуудлаар төрөлжсөн хамгийн том байгууллагыг 2 жил удирдах хариуцлагатай бөгөөд нэр хүндтэй үүргийг Монгол Улс хүлээв.





## НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

**Ногоон хөгжлийн бодлогыг 2 үе шаттай хэрэгжүүлэхээр боллоо. Ингэснээр та бидний өмнө тулгарч буй байгаль экологийн асуудлуудаас урьдчилан сэргийлэх, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах таатай нөхцөл үүсч байна.**

*1 дүгээр үе шат: Ногоон хөгжлийн үндсийг тавих үе. 2014-2020 он*

Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлж, бүс нутагтаа өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний салбар хөгжиж, мэдлэгт суурилсан эдийн засаг төлөвшиж, ногоон хөрөнгө оруулалт, санхүүжилтийн механизмаар байгальд ээлтэй, үр ашиг өндөртэй ногоон дэд бүтэц, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, цэвэр үйлдвэрлэлийн технологийг хөгжүүлж, нэгж бүтээгдэхүүнд ногдох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.





## НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### ***2 дугаар үе шат: Ногоон эдийн засагт шилжинэ. 2021-2030 он***

Хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, экосистемийн үйлчилгээний үр өгөөжийг ухаалгаар хүртэж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, өндөр үр ашигтай ногоон эдийн засаг, нийгмийн тэгш хүртээмжтэй тогтолцоо төлөвшсөн байна. Эдийн засгийн бүтцэд өндөр технологи, инноваци шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл давамгайлж, ногоон эдийн засагт шилжинэ.

Ногоон хөгжлийн бодлого бүрэн хэрэгжсэнээр Монгол орныхоо онгон байгалийг хэвээр хадгалж, үр хүүхдүүддээ өвлүүлж үлдээх учиртай.





## НОГООН ШИЙДЭЛ

“Ногоон хот” буюу эрчим хүч, дулаан, ус хангамж, харилцаа холбоо, нийтийн тээврийн ухаалаг дэд бүтэц, хог хаягдлын оновчтой менежмент бүхий хүний амьдралын тав тух, хөгжлийн боломжийг хангасан хот сууринг төлөвлөж байна.


“Ногоон барилга” буюу хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй материал ашигласан, дулааны алдагдал хамгийн бага байх хийцтэй, агаарт ялгаруулах хаягдал багатай халаалтын шийдэлтэй, эрчим хүч, нөөцийн хэмнэлт үр ашигтай, хур тунадасны усыг хуримтлуулж ашиглах, хаягдал бохир усаа цэвэрлэж зайлуулах технологи бүхий, тав тухтай орчныг бүрдүүлсэн барилга байгууламж баригдана.





## БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Байгальд ээлтэй тоног төхөөрөмжийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөв. Эрчим хүчний хэмнэлттэй чийдэн, бохир ус цэвэрлэх төхөөрөмж, нар, салхины цахилгаан үүсгүүр, ой, цэцэрлэгийн хөрс бэлтгэх төхөөрөмж зэрэг нийт 41 төрлийн байгальд халгүй зарим техник, тоног төхөөрөмж энэ чөлөөлөлтөд хамрагдаж байна. Хувийн хэвшлийнхэн болон хувь хүмүүс энэхүү боломжийг ашиглан цаашид ногоон тоног төхөөрөмжийг хэрэглээгээ болгосноор илүү их баяр баясгаланг мэдрэх болно.







## СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮД ЭКО БАРИЛГАТАЙ БОЛНО

2014 оны 3 дугаар сард НҮБ-ын “Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл” Дубайн уулзалтын үеэр Байгаль Орчин Ногоон Хөгжлийн сайд С.Оюун НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн гүйцэтгэх захирал Аким Штайнер нар шинээр барих сургууль цэцэрлэгийн барилгыг ногоон барилгын стандартад нийцүүлэх чиглэлээр хэлэлцэж тохиролцлоо. Цаашид ногоон сургууль, цэцэрлэгүүд баригдаж эхэлснээр бидний үр хүүхдүүд, дүү нар маань эрүүл, тав тухтай орчинд сурч, хүмүүжих боломжтой болно.





## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

Малын бэлчээрийн 70 хувь нь доройтож, даацаасаа 2-9 дахин хэтэрсэн өнөө үед, Уур амьсгалын өөрчлөлтөд улсынхаа эдийн засаг, ахуй амьжиргааг дээшлүүлэх тал дээр анхаарч ажиллах, улмаар цаашид тохиолдож болзошгүй сөрөг нөлөөллөөс хамгаалахын тулд иргэд, аж ахуйн нэгж та бүхний оролцоо нэн чухал юм.





## ХОГГҮЙ ХОТ

Орчин тойрондоо хог хаягдал хаях нь цэвэр цэмцгэр байдал, тав тухыг алдагдуулахаас гадна таны өөрийгөө болон бусдыг хүндлэх үзлийг үгүй болгох аюултай, цээрлэвэл зохих зүйл юм. Та бид цаашид хог хаягдалдаа анхаарч үр хүүхдүүд, балчир нялхасдаа илүү үлгэр дууриал болох шаардлага урган гарч байна. Хамгийн гол нь хог хаягдлаа ил задгай их хаяснаар агаарын болон хөрсний бохирдол үүсгэж эрүүл аж төрөх орчинд сөрөг нөлөө үзүүлдэг гэдгийг санаж явахад илүүдэхгүй байх.





## ХӨРСНИЙ БОХИРДОЛ

Химийн хорт бодис ихээр ялгаруулдаг арьс ширний үйлдвэрүүдийг хот суурин газраас холдуулах бэлтгэл ажлууд хийгдэж байгаа хэдий ч иргэн, аж ахуйн нэгж бид бүхний хийж чадах зүйл яндашгүй их билээ. Хөдөө орон нутагтаа эко бие засах газруудаа эко-суултуураар солих, угаадас, хаягдлаа зориулалтын газар асгаж хэвшвэл таны хашаа хороо өнгө засаж, улам өөдрөг болно гэдэгт итгэлтэй байна.





## АГААРЫН БОХИРДОЛ

Хот суурин газарт шилжилт хөдөлгөөн ихэссээр их хотын маань гэр хорооллын цар хүрээ огцом тэлсээр байна. Хүйтний улиралд гэр хорооллын болон дулааны цахилгаан станциудын утаа тортогоор амьсгалж байгааг та бэлхнээ мэдэх билээ. Энэ тал дээр төр засаг тодорхой арга хэмжээ авдаг боловч эх үүсвэрүүд хангалтгүй байна. Тиймээс иргэд та бид бүхэн галын зуух, автомашиндаа утаа шүүгч тавих, тоос тортог үүсгэх хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх зэрэг өөрсдөөс шалтгаалах бүхнээ хийж, агаарын бохирдлоо бууруулж эхэлцгээе.





## МОНГОЛ УЛСЫН ГОЛ МӨРӨН ХАРИУЦАХ ЭЗЭНТЭЙ БОЛЛОО

Монгол орны хэмжээнд гол горхи, нуурууд болон газрын доорхи усны нөөцийг хамгаалах, ашиглалт хэрэглээ бохирдол зэрэгт хяналт тавих, хүн ам, бэлчээр газар тариалангийн усан хангамжийг зохицуулах үүрэг бүхий төрийн захиргааны 29 байгууллага (Сав газрын захиргаа) болон нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий иргэдийн оролцоог хангасан Сав газрын зөвлөлүүд Туул, Улз гол, Тэс-Увс нуурын Сав газрын захиргааны дэргэд байгуулагдав. Ингэснээр Монгол хүмүүс бид нутаг орон, байгаль орчноо эзэнгүйдүүлэх асуудлуудыг бууруулж эхэллээ.





## УСНЫ УХААЛАГ ХЭРЭГЛЭЭ - УХАМСАРТАЙ ХЭМНЭЛТ

Засгийн газраас 2013 онд баталсан шинэ журмаар усны үнэ цэнэ, тарифыг нэмэгдүүлэх, мөн усаа дахин ашиглаж байгаа хэрэглэгчийн төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх эдийн засгийн урамшууллыг бүрдүүлсэнээр 2014 онд 73 сая тонн ус хэмнэсэн нь таатай хэрэг юм.

Чандмань эрдэнэ болсон усаа хайрлах нь та бидний үүрэг билээ.





## 170 000 ШООМЕТР МОД БҮХИЙ ОЙГ УСТГАГДАХААС ХАМГААЛАВ

2013 оны 6 дугаар сараас Монгол улсад импортоор оруулж ирэх мод, модон материалыг гааль, НӨАТ-ийн албан татвараас чөлөөлснөөр хэрэглээний модны нийлүүлэлт нэмэгдэж (2013 оны эхний хагаст 4,9 мянган шоометр мод импортоор орж ирж байсан бол 2014 оны мөн үед 18,8 дахин их буюу 87,2 мянган шоометр зүсмэл ОХУ-аас орж ирсэн), 1645 га талбай бүхий ойг сүйтгэхээс буюу 170 орчим мянган шоометр нойтон модыг бэлтгэхийг зогсоов. Мөн БОНХ Сайдын тушаалаар 2013 оноос төмөр замын дэрэнд мод хэрэглэхийг хориглосон бөгөөд жил бүр 25,0 мянган шоометр буюу 225 га ойг огтлохоос хамгаалан үлдээж байна. Ингэснээр бид бүхний амьсгалах цэвэр агаарын чанар муудахаас сэргийлж байна. Албан байгууллага, хувь хүн болгон гэртээ, гадаа, хашаандаа мод, бут тарьж хэвшицгээе.





**15**

## АРГАЛЬ, ЯНГИРЫГ НУТГИЙН ИРГЭД НЬ ХАМГААЛДАГ БОЛОВ

Агнуурын бүс нутагт ховор амьтны нөөцийг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах менежментийг бий болгож, шинэ журам гаргаснаар “хамгаалагч” буюу нутгийн иргэд нь тухайн амьтны нөөцийг ашиглах давуу эрхийг эдлэх болов. Ан амьтан агнасан төлбөрийг 100% тухайн сум, орон нутгийн төсөвт төвлөрүүлэн, төлбөрийн 85-аас доошгүй хувийг аргаль, угалз, тэхээ хамгаалах, бэлчээрийн менежментийг сайжруулахад зарцуулахаар боллоо. Энэхүү шийдвэр нь агнуурын амьтныг хамгаалах санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг бий болгож өгч байна.

Эх орноо хайрлах сэтгэлтэй иргэн бүхэн тухайн суурин газар, нутаг ус, ан амьтдаа өөрсдийн хүчээр хамгаалах нөхцөл бүрдлээ.





## ТӨР ШОНХОРОО АРИЛЖАХАА БОЛИВ

Монгол Улсын үндэсний бахархалт “Идлэг шонхор” шувууг ашиг олох зорилгоор гадаад оронд гаргахыг 5 жилээр хориглов. Нэг жилд 150-200 орчим Шонхор шувуу гадаадад арилжаалдаг байсан байна. Нэн ховордсон ан амьтдын хулгайн ангын талаар хамгийн ойр холбогдох газар мэдэгдэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байхыг нийт иргэддээ уриалж байна.

